

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ, ДИДАРСАНГАД ЗОЛЖАРГАЛ
2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулна.							
1	Их болон дунд эрсдэлтэй үнэлэгдсэн махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 9 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх.	1. Шалгалт хийсэн объектын тоо 2. Хууль сахин мөрдөлтийн түвшин; 3. Илрүүлсэн зөрчил, 4. Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь;	байхгүй	0	Объектын эрсдэлийн ангиллыг үндэслэн их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн нийт 9 объектыг төлөвлөснөөс 9 үйлдвэрт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 100%-тай хамруулсан. Төлөвлөгөөт хяналт шалгалтад хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 9 объектад хамрагдсан. Шалгалтаар - дунд эрсдэлтэй-1, бага эрсдэлтэй-8 үнэлэгдсэн. - Хууль сахин мөрдөлтийн түвшин 80%	3-р сар, 4-р сар, 5-р сар	100%

					- Эрсдэл үүсэх магадлал 20% - Зөрчлийн тоо 123 - Хяналт шалгалтын явцад нийт 123 зөрчил илрүүлж 106 зөрчлийг арилгах чиглэлээр газар дээр нь мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, 17 зөрчлийг арилгуулхаар хугацаатай 1 албан шаардлага хүргүүлсэн.		
2	Улсын хэмжээнд хиама, нөөшилсөн махан бүтээгдэхүүн, бууз баншны үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх /махан бүтээгдэхүүний давс, тослог, илчлэгийн хэмжээ, хүнсний нэмэлтийн агууламжид тандалт судалгаа хийх/	1. Зөрчлийн арилгуулалтын хувь 2. Улсын байцаагчийн авсан арга хэмжээ	байхгүй	Эрсдэлийн түвшинг бууруулна.	Төлөвлөгөөт шалгалтад хамрагдаагүй нөөшилсөн махны 3 үйлдвэр, бууз, баншны 12 үйлдвэрлэл эрхлэгч 4 аж ахуйн нэгж, 11 иргэд хамрагдав. Тус аж ахуйн нэгж болон цехүүдийн ажлын байр нь нэг чиглэлийн урсгалгүй 11 үйлдвэр, түүхий эд болох махны гарал үүсэл болон шинжилгээний бичиггүй 15 зөрчил, хүнсний нэмэлт, амтлагч нь шинжилгээний бичиггүй 8 зөрчил, эцсийн бэлэн бүтээгдэхүүнийг шинжилгээнд хамруулаагүй 4 зөрчил, сав баглаа боодол нь шинжилгээний бичиггүй 3 зөрчил, шошго дээр 100гр дахь илчлэг бичээгүй 5 зөрчил, бүртгэл журнал хөтөлж хэвшээгүй 8 зөрчил, ажилчид хөдөлмөр	6-р сар, 7-р сар	100%

					хамгааллын хувцсаар бүрэн хангагдаагүй 2 үйлдвэр, дотооддоо сургалт явуулдаггүй, цөөн тооны ажилтантай учир дотооддоо хяналт шалгалт хийдэггүй зэрэг зөрчил, дутагдал илэрсэн. Зөрчлийн шалтгаан нь хүнсний чиглэлийн мэргэжилтэй ажилтан байхгүй, хүнсний хууль болон стандартын мэдлэг дутмаг, санхүүгийн боломж муу байгаа нь гол шалтгаан болж байна.		
3	Мах, махан бүтээгдэхүүн, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийж, дүгнэлт гаргах	1. Ирсэн хүсэлтийн тоо 2. Биелэлтын %	1 үйлдвэр	Тухай бүр	Хагас боловсруулсан махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүсэлтэй 3 аж ахуйн нэгж, 1 цехээс ирүүлсэн албан бичгийн дагуу Эрүүл мэнд яам, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Салбарын хяналтын газрын даргын хамтран баталсан 10-00/14 дугаартай удирдамжаар 8.29.1 кодтой "Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэр шинээр эрхлэгчдэд урьдчилсан хяналт хийх" хяналтын хуудсаар төлөвлөгөөт бус шалгалт хийхэд тус 4 үйлдвэрийн ажлын байр нь "бага"	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%

					эрсдэлтэй үнэлэгдсэн тул ажлын байрны дүгнэлт олгов.		
4	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, эрсдэлийг бууруулах	1.Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тоо 2.Зөрчил арилгалтын хувь	14	Тухай бүр	Шинээр хүнсний үйлдвэрлэл эхлэх хүсэлтэй 49 цех, согтууруулах ундаа худалдах зорилгоор улсын байцаагчийн ажлын байрны дүгнэлт авахыг хүссэн 34 аж ахуйн нэгж нийт 83 газрын өргөдөлийг хүлээн авч төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Шалгалтаар нийт 521 зөрчлийг илрүүлсэн. Тус газруудад зөрчлөө арилгах чиглэлийн зөвлөмж, зөвлөгөө өгсөнөөр 356 зөрчлийг нь арилгуулсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
5	Мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд чиглэсэн сургалт хийх	1. Сургалтад холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж зохион байгуулсан байна. 2. Сургалтын үр дүнгийн үнэлгээг хийсэн байна. 3. Холбогдох хууль тогтоомж, стандартын талаар мэдлэг мэдээлэл олгож, хүнсний аюулгүй байдлыг хангуулах.	байхгүй	байхгүй	Орхон аймагт махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл эрхлэдэг 84 аж ахуйн нэгж, цехүүдэд 4 төрлийн сургалтыг хийж гүйцэтгэсэн. Сургалтын чиглэл нь хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хууль, стандартын хэрэгжилтийг биелүүлэх, үйлдвэрийн байрны ариутгал цэвэрлэгээг зөв хийх, хяналт шалгалтын чиглэлээр сургалтыг зохион байгуулласан	3-р сар	100%

1.2. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний эрүүл ахуй, чанар, аюулгүй байдлыг хангуулна.

6	Хүнсний үйлдвэрийн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн бялуун бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 6 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх;	1. Шалгалт хийсэн объектын тоо 2. Хууль сахин мөрдөлтийн түвшин; 3. Илрүүлсэн зөрчил, 4. Эрсдэлийн түвшин буурсан объектын тоо, хувь;	24	Хүнсний үйлдвэрлэлийн 6 объект	Удирдамжийн дагуу бялуун бүтээгдэхүүний 6 аж ахуй нэгж, цехд төлөвлөгөөт хяналт шалгалт хийсэн. – Шалгалтаар дунд эрсдэлтэй 3, бага эрсдэлтэй 3 - Хууль сахин мөрдөлтийн түвшин 73% - Эрсдэл үүсэх магадлал 27% - Зөрчлийн тоо 73 - Хяналт шалгалтын явцад нийт 73 зөрчил илрүүлж 30 зөрчлийг газар дээр арилгуулж үлдсэн зөрчлийг нь 43 заалт бүхий хугацаатай 3 албан шаардлага хүргүүлсэн.	3-р сар, 4-р сар, 5-р сар	100%
7	Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүд, улирлын чанартай ажил, үйлчилгээ, цаг үеийн шаардлагаар зохион байгуулж буй арга хэмжээнд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх	1. Шалгалт хийсэн объектын тоо 2. Илэрсэн зөрчил арилгалтын хувь	104	Хүнсний үйлдвэрлэлийн 30 объект	1. Урьдчилан сэргийлэх шалгалт болон сарын аяны хүрээнд хяналт шалгалтад 54 аж ахуйн нэгж, 74 цех нийт 128 газрыг хамруулсан. Хяналт шалгалтын явцад 418 зөрчлийг илрүүлэн 275 (66%)-ийг арилгуулан ажиллав. Хүнсний сүлжээний үе шат бүрт хэрэгжүүлэх зохистой дадал, дотоод хяналтын хэрэгжилт, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүсэл, чанар, аюулгүй	2-р сар, 5-р сар, 7-р сар, 12-р сар	100%

				байдлын баталгаажилд болон хүнсний аюулгүй байдлын талаар 658 заалт бүхий 80 зөвлөмж гаргаж хүргүүлсэн. 34 аж ахуйн нэгж, 153 иргэдэд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хүнсний чиглэлийн 5 төрлийн 94 ширхэг гарын авлага тарааж, цахим хуудсанд 13 удаа нийтэлсэн. 2. Орхон аймгийн баяр наадам, Эрдэнэт хот, Эрдэнэт үйлдвэрийг бүтээн босгосон Илгээлтийн эздийн 50 жилийн ойн баяр наадмыг 2024 оны 08 дугаар сарын 01-02-ны өдрүүдэд зохион байгуулагдсан. Баяр наадмаар хүнсний худалдааны 45, хоол үйлдвэрлэлийн 112, нийт 157 цэгт хяналт тавьж ажиллав. Хоол үйлдвэрлэлийн болон худалдааны хяналтаар 184 дутагдлыг илрүүлж газар дээр нь 124 зөрчил буюу 67%-ийг нь арилгуулсан. Зөрчилтэй хоол үйлдвэрлэлийн газруудаас газар дээр нь арчидасны шинжилгээ авч газар дээр нь цэвэрлэгээ хийлгүүлж ажилласан. Махны		
--	--	--	--	---	--	--

					шинжилгээний бичиг байхгүй, гадна талын өнгө нь өөрчлөгдсөн шорлогноос газар дээр нь арчидасны шинжилгээ хийхэд гадаргуун нянгын тоо 833 RLU буюу зөвшөөрөгдөх хэмжээнээс 8 дахин их байсан тул 216 ширхэг шорлогыг газар дээр нь хураан авсан. 3. Цах худалдааны төвд гал гарсны улмаас хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал нь алдагдсан 3 аж ахуйн нэгж 6 иргэн нийт 9 лангууны 690 нэр төрлийн 25549 ширхэг, 3507.2кг, 322.5л тоо хэмжээтэй нийт 198.605.200 төгрөгний үнэ бүхий хүнсний бүтээгдэхүүнийг устгасан.		
8	Гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд чиглэсэн сургалт хийх	Сургалтад холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, ажилтан албан хаагчдыг бүрэн хамруулж зохион байгуулсан байна. Сургалтын үр дүнгийн үнэлгээг хийсэн байна. Холбогдох хууль тогтоомж, стандартын талаар мэдлэг мэдээлэл олгож, хүнсний	30	байхгүй	1. Орхон аймагт хүнсний үйлдвэрлэл эрхлэдэг 175 аж ахуйн нэгж, цехүүдэд 4 төрлийн сургалтыг хийж гүйцэтгэсэн. Сургалтын чиглэл нь хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах, хууль, стандартын хэрэгжилтийг биелүүлэх, үйлдвэрийн байрны ариутгал цэвэрлэгээг зөв	3-р сар	100%

		аюулгүй байдлыг хангуулах.			хийх, хяналт шалгалтын чиглэлээр сургалтыг зохион байгуулласан. 2. Шинээр 2023-2024 онд хүнсний чиглэлийн үйлдвэрлэл хийж эхэлсэн нийт 35 аж ахуйн нэгж, цехийн захирал болон эзэд нарт хүнсний чиглэлийн хууль, ажлын байрны стандарт, бүртгэл хөтлөлт, хөдөлмөрийн аюулгүй байдлын чиглэлээр сургалт хийж чадавхжуулсан. 3. Төрийн байгууллагуудын хоорондын уялдаа холбоог сайжруулан, хувиараа хүнсний үйлдвэрлэл эрхлэгч нарын санхүүгийн дэмжлэгийн сонгон шалгаруулалтад анхаарч ажиллах чиглэлээр Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын мэргэжилтэн нарт шаардлагатай мэдээллээр сургалт өгч ажиллалаа.		
9	Өмнөх шалгалтын явцад илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар өгсөн албан шаардлагын биелэлтийг хангуулахаар гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх.	Албан шаардлагын биелэлтийн хувь	12 үйлдвэрт хийсэн.	Эрсдэлийн түвшинг бууруулна.	Гүйцэтгэлийн шалгалтыг нийт 4 үйлдвэрт хийхэд бүгд бага эрсдэлтэй болж -эрсдэл үүсэх магадлал 14.8% -хууль сахин мөрдөлт 85.2% болж өөрчлөгдсөн.	6-р сар, 7-р сар	100%

10	Shilenkhyanalt.gov.mn, https://www.igov.mn -д хяналт, шалгалтын тоон мэдээ, иргэн аж ахуйн нэгжийн бүртгэл оруулах, лавлагаа авах.	1.Хяналт шалгалтын тоон мэдээ 2.Бүртгэсэн аж ахуйн нэгжийн тоо	32 аж ахуйн нэгж, иргэн	Хяналт шалгалтын дүн мэдээг оруулж, шинээр хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн мэдээллийн сан бүрдүүлсэн байна.	1. Нийт 49 иргэнээс ирүүлсэн хүсэлтийн дагуу хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэх ажлын байрыг очиж шалгахад тус газрууд нь Хүнсний тухай хуулийн 10 дугаар зүйл /Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэхэд тавих шаардлага 10.1.2 - т стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх/ гэсэн заалтыг хангуулсны дараа lgov.mn цахим системд бүртгэж, бүртгэлийн хуудас өгсөн. lgov.mn цахим системээс хүсэлтийн дагуу 38 лавлагаа гаргаж өгсөн. 2. Shilenkhyanalt.gov.mn цахим системд 118 үйлдвэрийн эрсдэлийг үнэлж, төлөвлөгөөт шалгалт хийсэн 15 объект, сургалтад хамрагдсан 107 объект, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 59 объект, ажлын байрны дүгнэлт гаргуулсан 4 объектуудыг оруулж цахим мэдээллийн санд бүртгэсэн.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
----	---	---	----------------------------------	--	--	--	------

11	Хяналт шалгалтын үйл ажиллагаа, үр дүнг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд сурталчлах.	1.Телевизээр нэвтрүүлсэн мэдээллийн тоо 2.Сурталчилгааны тоо	Орон нутгийн телевиз-1 удаа, цахим орчинд-9 удаа	Байгууллагын үйл ажиллагаа, хяналт шалгалтын ажил, үр дүнг олон нийтэд мэдээлсэн байна.	Хүнсний зөв хэрэглээ, хадгалалт, худалдан авалт болон сонголт хийхдээ анхаарах асуудлын чиглэлээр 5 постер, 4 богино хэмжээний бичлэг, 14 төрлийн гарын авлага, хяналт шалгалтын явцын 6 мэдээг байгууллагын пэйж хуудсанд давтамжтайгаар байршуулж, хэрэглэгчийн боловсролыг дээшлүүлж байна.	2-р сар, 5-р сар, 7-р сар, 12-р сар	100%
3.1. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
12	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх				ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	100%
13	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,				70353511 тусгай дугаар болон и-оффисоор шилжин ирүүлсэн нийт 87 албан бичиг, өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд түрэн шуурхай, шийдвэрлэн	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар,	100%

	Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				хариу өгч, цахим системд хааж ажилласан. -Төлөвлөгөөт шалгалтын 15, төлөвлөгөөт бус шалгалтын 42, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын 5, хүсэлт гомдол 49 нийт 111 бичиг баримтыг архивт хүлээлгэн өгсөн.	8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	
3.2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх							
14	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод тарьж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх	Тарьсан модны тоо	2	1	Байгууллаг хамт олонтойгоо нийлж хавар намартаа 2 удаа мод тарьсан	5-р сар, 10-р сар	100%

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Мэдлэг, ур	Мэдлэг, ур	2	2	1. Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 сургалтад	10-р сар	100%

чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна	чадварыг дээшлүүлэх сургалтад хамрагдсан байна			нийт 8 удаа хамрагдсан. 2. ХХААХҮЯ-аас зохион байгуулласан 4 өдрийн Мах, махан бүтээгдэхүүн, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны техникийн хэрэгжилтийг хангах, дотор мах, дайвар бүтээгдэхүүний ашиглалтыг сайжруулах зорилгоор үйлдвэрийн байран дээрх сургалтанд оролцоно. Сургалтаар 1. Дотор махан уламжлалт бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэх технологийн онцлог, эрүүл ахуйн шаардлага 2. Төхөөрөх мал, амьтанд хийх үзлэг, бүртгэл хөтлөлт, түүнд хяналт тавих шаардлага, ач холбогдол-МЭЕГ-ын МАХИС систем танилцах 3. Хүнсний хэрэгцээнд тэнцэхгүй түүхий эд, бүтээгдэхүүнтэй харьцах, тэдгээрт боловсруулалт хийх, аюулгүй болгох арга технологи 4. Мал төхөөрөх, гулууз ба дотор мах, дайвар түүхий эдэд анхан шатны боловсруулалт хийх технологи – дадлага хийх 5. Дотор мах, дайвар түүхий эдийн эрүүл ахуй, аюулгүй байдлын олон улсын болон дотоод зах зээлийн шаардлага, MNS CAC RCP 5852: 2013 Махны эрүүл ахуйн дадлын дүрэм 6. Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн экспортлогчид тавих БНХАУ-ын хүнсний аюулгүй байдлын шаардлага (18 нэр төрлийн хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн) танилцах 7. Мах, дотор мах, дайвар түүхий эдийг хөргөх, хадгалах технологи, эрүүл ахуйн шаардлагатай танилцаж суралцсан. 3. Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулсан “Төрийн албаны шинэтгэл, сонгон шалгаруулалтын зохицуулалт” сургалтад цахимаар хамрагдаж, мэдээлэл авлаа. 4. Зөрчлийн хэрэг бүртгэл сэдэвт сургалтанд хамрагдсан. 5. Байгууллагын соёл		
--	--	--	--	--	--	--

				Байгууллагын зан харилцаа ба зөөлөн харилцаа сэдэвт сургалтад 6. ХАС ХОС-ын сургалтуудад идэвхтэй хамрагдаж суралцсан.		
--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:

ХҮНСНИЙ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ХЯНАЛТЫН

УЛСЫН БАЙЦААГЧ, ДИДАРСАНГАД ЗОЛЖАРГАЛ /........../

ОГНОО:.....